



ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 1/08

Биндэр сум

Эцэг эхийн зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалт, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхэд хамгааллын чиглэлээр бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “ Байгууллага аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын дэргэд ажиллах эцэг, эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичиг:	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан
Гишүүн:	Хөдөө аж ахуйн тасгийн дарга

2.Байгууллагын албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг жил бүр төлөвлөн хэрэгжилтийг зохион байгуулж хагас, бүтэн жилээр тайлагнахыг эцэг, эхийн зөвлөлд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/11 дугаартай тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Г.ӨНӨБОЛД